



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/574

Номгон

Хөдөөгийн багш нарын спортын 20 дугаар
их наадам зохион байгуулах ажлын
хэсэг томилох тухай

Улсын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хөдөөгийн багш нарын "Спортын их наадам" энэ оны хичээлийн жилд тус аймагт болохтой холбогдуулан Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөөгийн багш нарын "Спортын 20 дугаар их наадам"-ыг" Баянхонгор сумд 2023 оны 11 дүгээр сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Спортын их наадам зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Багш нарын спортын их наадмын бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулахыг ажлын хэсэг (В.Наранчимэг)-т үүрэг болгож, Спортын холбоодын тэргүүн нарт зөвлөсүгэй.

4.Хөдөөгийн багш нарын спортын их наадмыг өндөр зохион байгуулалттай харилцах туршлага солилцох, мэргэжил ур чадвараа дээшлүүлэх арга хэмжээ болгон зохион байгуулж, оролцохыг тэмцээнд оролцогч багш нарт уриалсугай.

5.Спортын их наадмын зардлыг хандивлагч, спортыг дэмжигч нараас бүрдүүлж, зарцуулж тайлагнахыг ажлын хэсэг /В.Наранчимэг/-т даалгасугай.

6.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч Б.Батсуурьд даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642311326

Аймгийн Засаг даргын ...онь... дүгээр
сарын ...ны өдрийн... захирал ажлын



**ХӨДӨӨГИЙН БАГШ НАРЫН СПОРТЫН ТИХ
НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЙМГИЙН
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч :	В.Наранчимэг	ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	С.Байгалмаа	ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Оюунбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга
	Н.Одончимэг	ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Мөнхцэцэг	Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Т.Ганболд-	ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн
	М.Угтахбаяр	Боловсрол, шинжлэх ухааны газрын биеийн тамир, хөгжмийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
	Ц.Загдсүм	Баянхонгор сумын "Эрдэм" ахлах сургуулийн захирал Захирлуудын холбооны дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Алтанцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....оОо.....